



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 03 өдөр

Дугаар A/65

Улаанбаатар хот

Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих
Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамж
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1 дахь хэсэг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3, 6.3.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтооолоор баталсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам", Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын Хөгжлийн Ассоциаци хооронд 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр байгуулсан Санхүүжилтийн хэлэлцээр, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан "Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх удирдамжийг нэгдүгээр, зээлийн өмнө болон дараах сургалт, санхүүгийн бус үйлчилгээ болон холбогдох үйл ажиллагааны төсвийг хоёрдугаар, зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээний жишиг зардлыг гуравдугаар, зээлийн өмнөх сургалтын үлгэрчилсэн хөтөлбөрийг дөрөвдүгээр, төслийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг хянах, үнэлэх аргачлалыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан удирдамжийн дагуу хөтөлбөрийн хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулан тайлagnаж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (З.Энхболд)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, төслийн захирал (Л.Батсайхан)-д даалгасугай.



Х.БУЛГАНТУЯА

• 151240201

БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 4 дүгээр тогтоолоор баталсан “Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр” (цаашид “хөтөлбөр” гэх)-ийг зохион байгуулалттай үр дүнтэй хэрэгжүүлэхэд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сум, хорооны хөдөлмөрийн асуудал хариуцсан албан хаагч, сонгон шалгарсан банкны ажилтныг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ

Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрт дараах иргэн хамрагдана.

- 2.1. Хувиараа хөдөлмөр эрхлэгч¹;
- 2.2. Малчин²;
- 2.3. Нэхөрлөл, хоршоо байгуулах иргэн³;
- 2.4. Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч⁴;
- 2.5. Гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэн⁵.

Гурав. Баримтлах зарчим

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дор дурдсан зарчмыг баримтална. Үүнд:

- 3.1. Арга хэмжээг хэрэгжүүлж, хянаж, үнэлэхдээ үр дүнд суурилсан зарчмыг баримтлах;
- 3.2. Арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын хамтын ажиллагааны хүрээ, талуудын эрх, үүрэг тодорхой байх;
- 3.3. Иргэдийг үл ялгavarлах;
- 3.4. Хэрэгжүүлэх арга хэмжээний нийгэм, байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлох, хязгаарлах, бууруулах;
- 3.5. Авилгаас урьдчилан сэргийлэх, авлигаас ангид ажиллах⁶;

¹ “Хувиараа хөдөлмөр эрхлэгч” гэж дангаараа болон бусадтай хамтран аж ахуй эрхэлж, татварын албанд бүртгүүлэн бизнесийнхээ үйл ажиллагаанд нөлөөлөх шийдвэрээ хараат бусаар бие даан гаргадаг иргэнийг;

² “малчин” гэж мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэнийг;

³ “Нэхөрлөл, хоршоо байгуулах иргэн” гэж Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу нэхөрлөл, хоршоогоо улсын бүртгэлд бүртгүүлэхээр хүсэлт гаргасан иргэдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг;

⁴ “Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч” гэж 50 хүртэл сая төгрөгийн үйлдвэрлэлийн хөрөнгө, эсхүл үйлчилгээний борлуулалтын орлого бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэнийг.

⁵ “Гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэн” гэж 6 сараас дээш хугацаагаар гадаад улсад ажиллаж, амьдарч байгаад сүүлийн 48 сарын дотор эх орондоо буцаж ирсэн иргэнийг хэлнэ.

⁶ Олон улсын Сэргээн босголт, хөгжлийн банк, Олон Улсын Хөгжлийн Асоцацийн зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилттэй төслийн баримтлах “Залилан, авлигаас урьдчилан сэргийлж, таслан зогсоо удирдамж” нь энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч бүх талуудад хамаатай болно.

- 3.6. Ил тод, нээлттэй байдлыг хангах;
- 3.7. Жижиг зээл авсан иргэдийн 50-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байх.

Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ

- 4.1. Жижиг зээлд хүсэлт гаргах боломжтой иргэдэд зориулсан зээлийн өмнөх сургалт;
- 4.2. Жижиг зээлийн арга хэмжээ;
- 4.3. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ.

Тав. Удирдлага, зохион байгуулалт

5.1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар зохицуулалт, арга зүйгээр ханган хяналт тавьж, шалгуур үзүүлэлтийн үр дүнг үнэлж, тайлагнаж ажиллана. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага хөтөлбөрийг тухайн орон нутагт сонгон шалгарсан арилжааны банктай хамтран зохион байгуулна.

5.2. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бизнесийн зөвлөгөө, сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудтай хамтран ажиллана.

Зургаа. Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээний зохион байгуулалт

6.1. Арилжааны банк сонгон шалгаруулах, гэрээ байгуулах

6.1.1. Жижиг зээл олгох үйл ажиллагааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/93 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийг дамжуулан олгох банкийг сонгон шалгаруулах удирдамж болон хоёрдугаар дугаар хавсралтаар баталсан банктай байгуулах гэрээний загварыг баримтлан зохион байгуулна.

6.1.2. Шалгарсан арилжааны банктай байгуулах гэрээнд бичил санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, эрүүл ахуйн шаардлагуудыг тусгасан байгаль орчин, нийгмийн удирдлагын систем (БОНУС)-ийг⁷ бий болгож, хэрэгжилтийг зохион байгуулахад зохицуулалтаар хангаж ажиллах шаардлагыг тусгана. Түүнчлэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь шалгарсан арилжааны банктай байгуулах гэрээнд банкууд жижиг зээл олгох болон тайлагнахдаа уг тушаалын 5 дугаар хавсралтын 2-6 дугаар маягтыг мөрдөж ажиллах талаар тусгана.

6.2. Мэдээлэл, сурталчилгаа

6.2.1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн талаарх мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдэд хүртээмжтэй хэлбэрээр түгээнэ.

6.3. Зээлийн өмнөх сургалт зохион байгуулах

6.3.1. Зээлийн өмнөх сургалтад хамрагдах хүсэлтэй иргэдийг аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага бүртгэнэ.

⁷Байгаль орчин, нийгмийн удирдлагын систем БОНУС нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд: (I) Байгаль орчин, нийгмийн бодлого; (II) Дэд төслийдийн байгаль орчны болон нийгмийн эрсдэл, нөлөөллийг тодорхойлох, үнэлэх, удирдах тодорхой журам; (III) Зохион байгуулалтын чадавх, чадамж; (IV) Нийт төслийд болон тодорхой төрлийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг хянах, үнэлэх; (V) Гадаад харилцааны механизмыг тодорхойлох.

6.3.2. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага зээлийн өмнөх сургалтыг үлгэрчилсэн хөтөлбөр⁸ болон зардлын жишгийг⁹ баримтлан зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд сургагч багш хөлсөөр ажиллуулж болно. Зээлийн өмнөх сургалтын хуваарийг олон нийт, зорилтот бүлэгт хүртээмжтэй түгээнэ.

6.3.3. Зээлийн өмнөх сургалтаар зээл хүсэгчдийн бизнесийн санааг хөгжүүлэх, аж ахуй эрхлэх төсөл, төлөвлөгөө боловсруулах, төсөл сонгон шалгаруулах аргачлал, шалгуур, баримт бичгийн бурдлийг хангуулах ур чадварыг эзэмшиүүлнэ.

6.3.4. Зээлийн өмнөх сургалтын агуулгад жижиг зээл олгохыг хориглох үйл ажиллагаа, бичил бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэлийг бууруулах, шийдвэрлэх Үүрэг хариуцлагын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын ерөнхий болон салбарын онцлогтой холбоотой мэдээлэл, Дэлхийн банкны Залилан, авлигаас урьдчилан сэргийлж, таслан зогсоох тухай удирдамж, гомдол барагдуулах механизм зэргийг тусгана.

6.3.5. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага зээлийн өмнөх сургалтыг мэргэжлийн сургалтын байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно. Энэ тохиолдолд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь сургалт, зөвлөгөө, чадавхжуулах сургалтын чанар болон төсвийн үр ашигтай зарцуулалтад хяналт тавьж ажиллана.

6.4. Төсөл боловсруулах, хүлээн авах

6.4.1. Төсөл бичих загварыг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар болон бусад мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэхээс гадна шаардлагатай бол олшруулж тараана.

6.4.2. Зээлийн өмнөх сургалтад хамрагдсан иргэн дараах материалыг бүрдүүлэн аймаг, дүүрэг, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын холбогдох мэргэжилтэнд хандана.

6.4.2.1. зээл хүссэн өргөдөл;

6.4.2.2. иргэний үнэмлэхийн хуулбар, аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар;

6.4.2.3. Зээлийн мэдээллийн санд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлгүй талаарх тодорхойлолт;

6.4.2.4. төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдээгүй талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт;

6.4.2.5. татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өргүй тухай тодорхойлолт;

6.4.2.6. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Хөдөө аж ахуйг дэмжих санд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй тухай тодорхойлолт;

6.4.2.7. барьцаалах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн болон эзэмших эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ, газрын гэрээ, кадастрын зургийн хуулбар;

6.4.2.8. ажлын байр нэмэгдүүлэх, хадгалах, үйл ажиллагаагаа өргөтгөх зорилго бүхий шаардлагыг хангасан төсөл.

⁸ Хавсрал 4. Зээлийн өмнөх сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр

⁹ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/16 дугаар тушаалын хавсралт, 5.4 дэх хэсэг

6.4.3. Энд заасан баримт бичгийг төрийн мэдээлэл солилцооны системээс шалгах боломжтой тохиолдолд зээл хүсэгчээс шаардахгүй байж болно.

6.5. Төслийн урьдчилсан сонгон шалгаруулалтын жагсаалт гаргах

6.5.1. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь жижиг зээл хүссэн бичил бизнес эрхлэгчдийн зээлийн төслийг урьдчилан шалгаруулах ажлын хэсгийг дараах 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулна.

6.5.1.1.аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага

6.5.1.2.жижиг зээлийг дамжуулан зээлдүүлэх банкны орон нутаг дахь салбарын төлөөлөл,

6.5.1.3.жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв,

6.5.1.4.сүүлийн 3 жилийн турш бичил бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулсан төрийн бус байгууллага

6.5.1.5.тухайн орон нутгийн иргэний төлөөллийг (нээлттэй зарласны үндсэн дээр)

6.5.2. Ажлын хэсэг сард 2-оос доошгүй удаа хуралдаж, жижиг зээлийн төслийг урьдчилсан байдлаар шалгаруулж, жагсаалт гаргана.

6.5.3. Сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан зээл хүсэгчээс ирүүлсэн баримт бичиг, төслийг аймгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажлын 3 хоногийн дотор цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

6.5.4. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын холбогдох ажилтан ирүүлсэн төсөлд анхан шатны үнэлгээ хийж, жижиг зээлийн төслийн үнэлгээний нарийвчилсан жагсаалтыг гарган дараах шаардлагыг хангаж байгаа эсэхийг үнэлнэ. Үүнд:

6.5.4.1. зорилго, хүрэх үр дүн, ашигт ажиллагаа тодорхой байх;

6.5.4.2. ажиллах хүч, техник, тоног төхөөрөмжийн нөөц болон үйл ажиллагаа явуулах ажлын байр, орчныг тооцсон байх;

6.5.4.3.нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөсөн байх;

6.5.4.4. хүсэж буй зээлийн мөнгөн дүнгийн 40 болон түүнээс дээш хувьд хүрэлцэхүйц барьцаа хөрөнгөтэй байх;

6.5.4.5.төслийн хүрээнд байнгын ажлын байр бий болгож, цаашид хадгалах боломжтой байх.

6.5.5. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын холбогдох ажилтан дээрх шалгуур үзүүлэлт бүрийг 1-10 оноогоор үнэлж, дүнг нэгтгэн хамгийн өндөр оноо авсан зээл хүсэгчээс эхлэн эрэмбэлж, жагсаалт гаргана.

6.5.6. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын холбогдох ажилтан 4.5.3, 4.5.4 -т заасны дагуу үнэлсэн төслийн дэлгэрэнгүй жагсаалтыг ажлын хэсэгт ирүүлж урьдчилсан шалгаруулалтад оруулна.¹⁰ Ажлын хэсэг хуралдаж, дэлгэрэнгүй жагсаалтад орсон зээл хүсэгчидтэй танилцаж, зөвшилцсөний үндсэн дээр төслийг сонгон шалгаруулах шийдвэр гаргана.

6.5.7. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага жижиг зээл хүсэгчийн төслийг сонгон шалгаруулахдаа жижиг зээл олгохыг хориглох үйл ажиллагааны жагсаалт¹¹-д орсон бизнесийн төслийг дэмжихгүй.

¹⁰ Аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага болон жижиг зээл олгохоор сонгогдсон банкны орон нутаг дахь салбарын төлөөлөл, ЖДУ-ийг дэмжих төв, бичил бизнес эрхлэгчдийг дэмжих үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, орон нутгийн иргэд гэсэн таван хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг.

¹¹ Хүснэгт 1. Жижиг зээл олгохыг хориглох үйл ажиллагааны жагсаалтыг үзнэ үү.

6.5.8. Төсөл нь шалгараагүй тохиолдолд төслөө сайжруулан дахин ирүүлэх боломжтой. Энэ тохиолдолд зээлийн өмнөх сургалтад дахин хамрагдах шаардлагагүй.

6.5.9. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага ажлын хэсгээс шалгарсан болон шалгараагүй төслийн жагсаалтыг мэдээллийн самбар, цахим хуудсаараа дамжуулан нээлттэй мэдээлнэ.

6.6. Сонгон шалгаруулалтад тэнцсэн бизнесийн төслийг хянаж зээл олгох

6.6.1. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь урьдчилж сонгогдсон зээл хүсэгчдийн жагсаалтыг ирүүлсэн төслийн хамт сонгогдсон банкуудын орон нутаг дахь салбар нэгжид ажлын 2 хоногт хүргүүлнэ.

6.6.2. Банк нь зээлийн хүсэлт, төсөл болон холбогдох материалыг бүрэн хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор жижиг зээлийг судалж шийдвэрлэнэ.

6.6.3. Жижиг зээлийн саналыг урьдчилж шалгах, сонгон шалгаруулах зорилго бүхий аймаг дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага дээр байгуулагдсан ажлын хэсэг болон энэ асуудлыг хариуцсан мэргэжилтэн ирүүлэн төсөл тус бурийг зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны жагсаалтын дагуу байгаа эсэхийг шалгана. Хэрэв жижиг зээлийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь энэхүү зөвшөөрөгдсөн жагсаалтад ороогүй байвал санхүүжүүлэхээс татгалзана (Хавсралт 5, Хүснэгт 1-д заасан жагсаалтыг ашиглана).

6.6.4. Банк нь бичил бизнес эрхлэгчийн ирүүлсэн зээлийн хүсэлт болон төслийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн эрсдэлийг шалгана. Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн шинжилгээ хийхдээ Хавсралт 5, Хүснэгт 2-ыг ашиглана. “Өндөр эрсдэлтэй ангилалд” хамаарах бизнесийн үйл ажиллагаа нь жижиг зээлийн санхүүжилтэд хамрагдахгүй. Зөвхөн дунд болон бага эрсдэлтэй төслүүд зээлийн санхүүжилтэд хамрагдах боломжтой.

6.6.5. Банк нь зээлийн хүсэлт гаргагч бичил бизнес эрхлэгчийн төслийг хүлээж аваходаа тухайн хүсэлт гаргагч нь Дэлхийн банкны Байгаль орчин, нийгэм, эрүүл мэндийн ерөнхий¹² болон салбарын тухайлсан удирдамжийг дагаж мөрдөх шаардлага тавьж, “дунд зэргийн нөлөөтэй” ангилалд хамаарах зээлдэгчийн төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөг хязгаарлах, бууруулах шаардлагыг Хавсралт 5, Хүснэгт 3-ын дагуу баталгаажуулна. Банк нь зээлдэгч бүрийг Дэлхийн банкны ерөнхий болон салбарын байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны удирдамжаар хангана.

6.6.6. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас баталсан тайлангийн маягтын дагуу жижиг зээл олгосон тайланг сар бүр банкнаас хүлээн авна. Банк нь “дунд зэргийн нөлөөтэй” ангилалд хамаарах зээлдэгчийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн эрсдэлийн хяналт-шинжилгээ хийсэн тайланг Хавсралт 5, Хүснэгт 6-ын дагуу гарган Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад улирал тутамд хүргүүлнэ.

¹² Хүснэгт 4.: Жижиг зээлийн төслийг хэрэгжүүлэх явцад баримтлах байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын ерөнхий удирдамж

6.6.7. Зээлдэгчийн үйл ажиллагаа байгаль орчин, нийгэмд их хэмжээний нэлөө үзүүлж байгаа нь тогтоогдвол банк тухайн асуудлыг, шийдвэрлэх зорилгоор холбогдох байгууллагад мэдэгдэх эрхтэй.

6.7. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг зохион байгуулах

6.7.1. Жижиг зээл авсан бичил бизнес эрхлэгчид зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээнд хамрагдана. Уг арга хэмжээний төсвийг аймаг, дүүрэгт хуваарилахдаа хөтөлбөрийн хүрээнд жижиг зээлд хамрагдсан хүний тоог харгалзан тогтооно.

6.7.2. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ гуравдугаар хавсралтаар баталсан зардлын жишгийг баримтална.

6.7.3. Жижиг зээлийг нийслэлийн 9 дүүрэг болон 21 аймгийн бичил бизнес эрхлэгчдэд олгоно. Зээлдэгч нь суманд оршин суудаг бол зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээнд хамрагдах унаа болон холбогдох бусад зардлыг өөрөө хариуцна.

6.7.4. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэх байгууллагыг дараах шалгуурын дагуу сонгон шалгаруулна. Үүнд:

6.7.4.1. Бизнес хөгжлийн сургалт зохион байгуулах, эсвэл зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх авсан,

6.7.4.2. Бизнес хөгжлийн сургалт, зөвлөгөө, менторингийн үйл ажиллагаа тогтмол явуулдаг,

6.7.7.3. Бизнес хөгжлийн сургалтын хөтөлбөрүүдтэй, 3-аас доошгүй жил бизнес хөгжлийн сургалт, зөвлөгөө өгсөн туршлагатай багштай¹³,

6.7.7.4. Бизнесийн зөвлөн туслах буюу менторинг үйлчилгээ үзүүлдэг туршлагатай зөвлөхүүдтэй байх эсвэл тийм зөвлөхүүдтэй хамтран ажилладаг¹⁴,

6.7.7.5. 21 аймгийн хувьд тухайн орон нутагт тогтмол үйл ажиллагаа явуулдаг,

6.7.7.6. Бизнесийн зөвлөх байгууллагуудын холбоо, нийгэмлэгийн гишүүн байх нь давуу тал болно.

6.7.5. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээнд хамрагдах иргэдийн тоог гаргах бөгөөд шаардлагатай бол нэгээс олон байгууллагыг сонгож болно.

6.7.6. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага сонгон шалгаруулалтын шийдвэр, үндэслэлийг ажлын хэсгийн шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногийн дотор байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар болон бусад хэрэгслээр олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

6.7.7. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэх байгууллагатай хийх гэрээний загварыг Хөдөлмөр, хalamжийн үйлчилгээний ерөнхий газар баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Сонгогдсон байгууллагатай байгуулсан гэрээнд санхүүгийн бус үйлчилгээнд хамрагдах зээлдэгчдийн тоо анх төлөвлөснөөс өөрчлөгдсөн тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

¹³ Хөтөлбөр болон мэргэжил, ур чадвар, ажлын туршлагыг харуулсан анкетыг хавсаргана.

¹⁴ Бизнесийн хөгжлийн зөвлөхүүдийн мэргэжил, ур чадвар, ажлын туршлагыг харуулсан анкетыг хавсаргана.

6.7.8. Бизнес хөгжлийн сургалт нь 20 цагийн хөтөлбөртэй, танхим болон цахим (зайн) хосолсон хэлбэрээр уян хатан байдлаар зохион байгуулна.

6.7.9. Бизнесийн зөвлөн туслах үйлчилгээ нь зээлдэгчийн хэрэгцээ шаардлагаас хамааран 10 цагийн хугацаатай байна. Амжилттай бизнес эрхлэгч бизнесийн зөвлөгөөг өгөх бөгөөд нэг зөвлөгчийн дадлагажигчийн тоо сард 5-аас илүүгүй байна. Ижил төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэдэд зөвлөн туслах үйлчилгээг бүлгээр зохион байгуулж болно.

6.7.10. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага зээлдэгчдийн нэрсийн жагсаалт¹⁵, холбогдох мэдээллийг зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэх байгууллагад тухай бүр хүргүүлнэ.

6.7.11. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага болон зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэх байгууллага хамтран Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас баталсан загварын дагуу зээлдэгч бүрийн санхүүгийн бус үйлчилгээний хэрэгцээ, хүрэх үр дүнг тодорхойлж, хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажиллана.

6.7.12. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээний явц, хэрэгжилт, үр дүнд хяналт, үнэлгээ хийнэ.

6.7.13. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэгч байгууллага үйл ажиллагааны явцын тайланг гэрээ байгуулсан өдрөөс хойш сар тутамд, эцсийн тайланг гэрээний хугацаа дууссанаас хойш нэг сарын дотор аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад хүргүүлнэ.

6.7.14. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь явцын тайланг хүлээн авч, гэрээний биелэлтэй танилцсанаас хойш ажлын 10 хоногийн дотор санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэх санхүүжилтийг шилжүүлнэ. Шилжүүлэхдээ санхүүгийн бус үйлчилгээг авч дууссан оролцогчдын тоонд үндэслэнэ.

6.7.15. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага бизнес харилцаа холбоо тогтоох, туршлага судлах, нэмүү өргтгийн сүлжээнд холбох, үйлдвэрлэлийн дэвшилтэт технологи, санаачилгын талаар мэдээлэл түгээх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж болно.

6.7.16. Аймаг, дүүрэгт зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэгчдийг чадавхжуулах сургалтыг төсөл хэрэгжүүлэх нэгжээс мэргэшсэн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлнэ.

Долоо. Хяналт-үнэлгээ, тайлагналт

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага байнгын хяналт тавина.

7.2. Хөтөлбөрийг хянаж, үнэлэхэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хүрээнд баримтлах хяналт, үнэлгээ, тайлагналтын журмыг мөрдөнө. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн хяналт, үнэлгээг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар жилд 2-оос доошгүй удаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам жилд 1-ээс доошгүй удаа хийнэ.

7.3. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтийн сарын тайлан, мэдээг дараа сарын 3-ны дотор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт, тус газар нь тайлан, мэдээг нэгтгэн дүгнэж мөн сарын 5-ны дотор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлнэ.

¹⁵ Хөтөлбөрийн хүрээнд жижиг зээл авсан иргэдийн нэрсийн жагсаалт

7.4. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх болон хамрагдаж буй иргэдийн мэдээллийг тогтсон загварын дагуу хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд тогтмол бүртгэж, шинэчилнэ.

7.5. Хөтөлбөрийн үр дүнг хянаж, үнэлэхэд захиргааны журмаар тогтмол давтамжтай цуглувулсан тоо мэдээ, хөтөлбөрийн хэрэгжилттэй газар дээр нь танилцаж цуглувулсан чанарын мэдээ, үр шим хүртэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа, хөндлөнгийн мөшгөх судалгаа зэрэг арга хэрэгслийг зохистой хэлбэрээр ашиглана.

7.6. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны бүртгэл, хяналт, тайлангийн маягтын дагуу оролцогч талуудаас тайлан, мэдээг цахим хэлбэрээр хүлээн авах техникийн нөхцөлийг хариуцан зохион байгуулна.

7.7. Хөтөлбөрийн санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан, бичиг баримт хуурамчаар үйлдсэн болон бусад зөрчил, дутагдал гаргасан нь холбогдох байгууллагаас хийсэн хяналт, шалгалтаар тогтоогдвол олгосон санхүүжилтийг буцаан төлүүлэх арга хэмжээ авч, буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

7.8. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, арилжааны банкууд болон бусад хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талууд авлигаас ангид ажиллаж "Олон улсын Сэргээн босголт, хөгжлийн банк, Олон улсын Хөгжлийн ассоциацийн зээл, буцалтгүй тусlamжийн санхүүжилтээр хэрэгжиж буй төслүүдэд залилан, авлигаас урьдчилан сэргийлж, таслан зогсоо тухай удирдамж"¹⁶-ыг баримталж ажиллана. Уг удирдамж нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон жижиг зээл олгохоор сонгогдсон банк хооронд байгуулах гэрээний салшгүй хэсэг болно.

Найм. Хөтөлбөрт хамрагдаж буй бичил бизнес эрхлэгчдийн байгаль орчны эрсдэл, нийгэмд үзүүлэх нөлөөллийг шийдвэрлэх

8.1. Талуудын оролцоог хангах

8.1.1. Хөтөлбөрийн хүрээнд иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах, санал солилцох, ил тод, хүртээмжтэй байдлыг хангах механизмыг бэхжүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

8.1.1.1.бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан үр шим хүртэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнг хянах;

8.1.1.2.хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжилтийн талаар оролцогч талуудтай тогтмол санал солилцох, зөвлөлдөх;

8.1.1.3.хөтөлбөрт оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

8.1.1.4. холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн санал, гомдол хүлээн авч, цаг тухайд нь, үр дүнтэй хянан шийдвэрлэх гомдол барагдуулах механизмыг нэвтрүүлж, хэрэгжүүлэх. Үүний тулд зээлийн өмнөх сургалтад хамрагдагчдад хөтөлбөртэй холбоотой өргөдөл, гомдлыг барагдуулах тогтолцооны талаар зохих мэдээллээр хангана.

8.1.2. Хөтөлбөрт үндэсний цөөнх казах иргэдийн оролцоо, хүртэх үр шимийг нэмэгдүүлэх зорилгоор хөтөлбөрийн талаарх мэдээллийг казах хэлээр бэлтгэж, түгээнэ.

¹⁶ Гэрээ бүрийн хавсралтаас харна уу.

8.1.3. Бичил бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд хөтөлбөрийн мэдээллийг хүртээмжтэй хүргэх замаар хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэйчүүдийн оролцоог дэмжихэд онцгой анхаарч хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх бүх арга хэмжээнд хамрагдсан үр шим хүртэгчдийг хүйсээр ялган тайлагнана.

8.1.4. Бизнесийн үйл ажиллагаагаа эхлүүлэх, бэхжүүлэхийг эрмэлзэж буй залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг зорилтот бүлэгт чиглэсэн мэдээлэл түгээх үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

8.2. Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлага

8.2.1. Хөтөлбөрийн хүрээнд жижиг зээл олгохыг хориглох үйл ажиллагааны жагсаалтад¹⁷ хамаарах байгаль орчин, нийгэмд нөхөн сэргээх боломжгүй, ноцтой, томоохон эрсдэл, хохирол учруулах үйл ажиллагаа, бичил бизнесийг дэмжихгүй. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь төслийг урьдчилан шалгахдаа ийм үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй байхад анхаарна.

8.2.2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь жижиг зээлийн санхүүжилт олгохоор сонгогдсон арилжааны банкууд зээл олгох явцдаа Байгаль орчин, нийгмийн удирдлагын систем (БОНУС)-ийг баримталж буй эсэхийг хариуцаж ажиллана. Арилжааны банкууд нь бичил бизнес эрхлэгчээс ирүүлсэн төслийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг бууруулах үүрэг хариуцлагад хяналт тавьж¹⁹ (Хавсралт 5, Хүснэгт 5-ын дагуу), хяналтын тайланг (Хавсралт 5, Хүснэгт 6-ын дагуу)²⁰ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт улирал тутам хүргүүлнэ.

8.2.3. Арилжааны банк нь “дунд зэргийн нөлөөтэй” ангилалд хамаарах зээлдэгчийн төслийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөг хязгаарлах, бууруулах шаардлагыг баталгаажуулж²¹, жижиг зээлийн төслийг хэрэгжүүлэх явцад баримтлах байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын ерөнхий удирдамж²² болон салбарын тухайлсан удирдамжийг дагаж мөрдөхийг шаардана. Арилжааны банкууд эцсийн зээлдэгчидтэй байгуулах зээлийн гэрээнд зээлдэгчийн төслийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг бууруулах үүрэг, хариуцлага болон Байгаль орчин, нийгэм, эрүүл мэндийн ерөнхий болон салбарын удирдамжийг дагаж мөрдөх талаар тусгана.

8.2.4. Их хэмжээний зөрчил илэрсэн тохиолдолд арилжааны банк нь үр нөлөөг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэхээр эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

8.2.5. Арилжааны банк нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт тайлагнах зохих бүртгэлийг хөтөлнө. Байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцооны талаар тайлагнах хүснэгтийг Арилжааны банктай байгуулах гэрээнд

¹⁷ Гуравдугаар хавсралт, Хүснэгт 1. Жижиг зээл олгохыг хориглох үйл ажиллагааны жагсаалтыг үзнэ үү.

¹⁸ Хүснэгт 2. Жижиг зээлийн санхүүжилтээр хэрэгжих бичил бизнесийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг үнэлэх маягт

¹⁹ Хүснэгт 5. Бичил бизнес эрхлэгчдийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөлд хяналт тавих загвар

²⁰ Хүснэгт 6. Жижиг зээлийн санхүүжилтээр хэрэгжиж буй бичил бизнесийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний тайлангийн маягт

²¹ Хүснэгт 3: Жижиг зээл хүснэгчийн бизнесийн төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөг хязгаарлах, бууруулах шаардлагыг биелүүлэхээ баталгаажуулах маягт

²² Хүснэгт 4.: Жижиг зээлийн төслийг хэрэгжүүлэх явцад баримтлах байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын ерөнхий удирдамж

хавсаргах бөгөөд хяналтын тайланг (Хавсралт 5, Хүснэгт 6-ын дагуу)²³ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт улирал тутам хүргүүлнэ.

8.2.6. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагууд бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд бичил аж ахуйн нэгжийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн хяналт, үнэлгээний үр дүнг тусгана.

---оо---

²³ Хүснэгт 6. Жижиг зээлийн санхүүжилтээр хэрэгжиж буй бичил бизнесийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний тайлангийн маягт

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2024 оны 1 дугаар сарын 15-ны өдрийн
1 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**ЗЭЭЛИЙН ӨМНӨХ, ДАРААХ СУРГАЛТ, САНХҮҮГИЙН БУС ҮЙЛЧИЛГЭЭ БОЛОН
ХОЛБОГОДОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ**

№	Арга хэмжээ	2024 оны төсөв	
		Хамрагдах хүн	Хөрөнгө /төгрөг/
1	Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийн өмнөх болон зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ	Зээлийн өмнөх сургалт	2,500
		Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ	550
2	Зээлдэгчдийн үйлдвэрлэсэн бараа бутээгдэхүүнийг сурталчлах ажлыг аймаг, дүүрэгт зохион байгуулах /үзэсгэлэн, яармаг, өдөрлөг/		102,270,000
3	Жижиг зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэх сургагч багш нарыг бэлтгэх, сургалтын агуулгыг сайжруулах		51,135,000
4	Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн танилцуулга, материал бэлтгэх, олон нийтэд түгээх сурталчлах		51,135,000
5	Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ		102,270,000
	Нийт дүн		450,560,000

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2024 оны 1 дугаар сарын 03-ний өдрийн A/65
дугаар тушаалын гуравдугаар хавсралт

Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээний жишиг зардал

№	Санхүүгийн бус үйлчилгээ	Зардлын төрөл, хэмжээ /нэг хүнд/
1.	Бизнес хөгжлийн сургалт (20 цаг)	1.1. Сургалтын зардал /нэг өдөрт/ 1 хүн = 15,000 төгрөг
2.	Бизнесийн зөвлөн туслах Үйлчилгээ (10 цаг)	2.1. Ганцаарчилсан зөвлөх үйлчилгээний зардал /нэг цагт/ 1 хүн = 8,000 төгрөг 2.2. Ижил төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэдэд бүлгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх зардал /нэг цаг/ 1 хүн = 6,000 төгрөг

---оо---

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2024 оны 4 дугаар сарын 03-ны өдрийн
A/6 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

ЗЭЭЛИЙН ӨМНӨХ СУРГАЛТЫН ҮЛГЭРЧИЛСЭН ХӨТӨЛБӨР

Хугацаа	Сэдэв	Хэн хариуцах
Эхний өдөр		
Үдээс өмнө	<ul style="list-style-type: none"> Сургалтын нээлт Сургалтын зорилгыг танилцуулах 	Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага
	Танилцуулга ²⁴ :	Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага
	<ul style="list-style-type: none"> Бичил бизнес эрхэлдэгчийг дэмжих арга хэмжээний бүрэлдэхүүн хэсгүүд, үйл ажиллагааны үе шатууд Зорилтот бүлэг 	Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага
	Завсарлага (20 мин)	
Үдээс хойш	<ul style="list-style-type: none"> Жижиг зээлийн нөхцөл, зээл олгож буй банкны шаардлага, бүрдүүлэх бичиг баримт Жижиг зээлийн төсөл сонгон шалгаруулах аргачлал, шалгуур 	Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага
	Завсарлага (1 цаг)	
	<ul style="list-style-type: none"> Бизнесийн төслийн байгаль орчин, хүний эрүүл мэнд, аюулгүй байдлын шаардлагууд болон жижиг зээлээр санхүүжүүлсэн бизнесийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг бууруулахад зээлдэгчийн гүйцэтгэх үүрэг 	Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага/ Сургагч багш
Хоёр дахь өдөр	Завсарлага (20 мин)	
	<ul style="list-style-type: none"> Бизнесийн санаа хөгжүүлэх, бизнес төсөл, төлөвлөгөө боловсруулах сургалт 	Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага/ Сургагч багш
	Завсарлага (1 цаг)	
Үдээс хойш	<ul style="list-style-type: none"> Бизнесийн санаа хөгжүүлэх, бизнес төсөл, төлөвлөгөө боловсруулах сургалт (үргэлжлэл) 	Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага/ Сургагч багш
	Завсарлага (20 мин)	
Үдээс өмнө	<ul style="list-style-type: none"> Бизнесийн санаа хөгжүүлэх, бизнес төсөл, төлөвлөгөө боловсруулах сургалт (үргэлжлэл) 	Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага/ Сургагч багш
	Завсарлага (1 цаг)	
Үдээс хойш	<ul style="list-style-type: none"> Залилан, авлигаас урьдчилан сэргийлж, таслан зогсоох тухай удирдамж Санал, гомдол хүлээн авах, барагдуулах механизм Ярилцлага, асуулт, хариулт Сургалтын хаалт 	Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага

²⁴ Танилцуулга бүрийн дараа 20-оос доошгүй минутын асуулт хариултын цаг гаргана.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2024 оны 26 дугаар сарын 28-ны өдрийн
А/бз дугаар тушаалын тавдугаар хавсралт

Жижиг зээл хүсэгчийн санал болгож буй тесэл, бизнесийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нэвтрүүлийг хянах, үнэтэх аргачлал

Хүснэгт 1: Жижиг зээл олгохыг хориглох үйл ажиллагааны жагсаалт (Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн ажилтан ашиглах)

Хориглох үйл ажиллагаа	
Тусгай газар нутаг болон байгаль орчинд үерөг нөлөө үзүүлж болзошгүй аливаа үйл ажиллагаа	Цацраг идэвхт бүтээгдэхүүн болон цөмийн реакторын төхөөрөмж оролцуулсан аливаа үйл ажиллагаа
Хотын захирагаанаас тогтоосон ногоон бусэд орших аливаа үйл ажиллагаа	Хүний эрүүл мэндэд ноцтой үерөг нөлөө үзүүлж болзошгүй аливаа үйл ажиллагаа
Маргаантай газар нутагт хэрэгжих аливаа үйл ажиллагаа	Монреальын Протоколын дагуу хлорфлюорокарбон (CFCs), халон (halons) эсвэл озон задлах бусад бодис агуулсан тоног төхөөрөмж, хэрэгслийн үйлдвэрлэл зэрэг үйл ажиллагаа
Хүмүүсийг нүүлгэн суурьшуулах, эсвэл нүүлгэн шилжүүлэлт шаардсан аливаа үйл ажиллагаа	Жинингээрээ 0.005 хувиас илүү полихлорт бифенил (PCBs) агуулсан цахилгаан хэрэгслийн үйлдвэрлэл бүхий аливаа үйл ажиллагаа
Соёлын өвд гэмтэл, хохирол учруулж болзошгүй аливаа үйл ажиллагаа	Хориотой пестицид, гербицид үйлдвэрлэх, худалдаж авах, түгээх, худалдах үйл ажиллагаа
Угуул нутгийн болон бусад эмзээг булагийн иргэдийн газар нутаг, эрхэд хапдсан аливаа үйл ажиллагаа	2022 онд батлагдсан Насанд хүрээгүй хүн ажиллахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг зөрчиж насанд хүрээгүй хүн ажиллуулах аливаа үйл ажиллагаа
Нийгэмд ноцтой үерөг нөлөө үзүүлэх болон нийтийн томоохон зөрчилүүсээг болзошгүй аливаа үйл ажиллагаа	Зэрлэг ан амьтан, ургамлын нэн ховордсон төрөл зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн хүрээнд хориглосон зэрлэгт амьтан ургамал, тэдээрийн гаралтай бүтээгдэхүүний арилжаа худалдаа бүхий аливаа үйл ажиллагаа
Монгол Улсын хуулиар хориглосон аливаа үйл ажиллагаа	Генетикийн өөрчлөлттэй бүтээгдэхүүнийг байгаль орчинд нийлүүлэхтэй холбоотой аливаа үйл ажиллагаа
Байгаль орчинд ноцтой үерөг нөлөө үзүүлэх аливаа үйл ажиллагаа	Аюултай хог хаягдлыг хадгалах, ашиглах, зайлцуулхтай холбоотой аливаа үйл ажиллагаа
Оршин сух эсвэл хувийн хэвшлийн худалдааны зориулалттай байшин барилтыг буулгах эсвэл	Дараах салбаруудад хамаарах аливаа үйл ажиллагаа: • Мод бэлтгэл • Ул Уурхай, олборлох ажил

газрыг чөлөөлөх асуудал бүхий аливаа үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Тамхины бүтээгдэхүүний үйлдвэрлэл Цэргийн техник хэрэгслийн үйлдвэрлэл Кокс, химийн бодис, хуванцар эсвэл эмийн бутаагдажхүүний үйлдвэрлэл
Хөдөлмөрийн менежментийн томоохон эрсдэлтэй, хөдөлмөрийн нөхцөл, агуулгүй байдал, эрүүл мэндэд эрсдэл учруулах аливаа үйл ажиллагаа, албадаан болон хүүхдийн хөдөлмөр эрхлэлт	<p>Олон нийтийн эрүүл мэнд, агуулгүй байдалд ихэхэн эрсдэл учруулах аливаа үйл ажиллагаа (Унд замын хөдөлгөөний аюулгүй байдал, хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөн, халдварт өвчний тархалт, аюултай материал ашиглах)</p>

Хүснэгт 2: Жижиг зээлийн санхүүжилтээр хэрэгжих бичил бизнесийн үйл ажиллаганы байгаль орчин, нийтэмд үзүүлэх

Нөхөөллийг үнэлэх маягт

(Энэхүү маягтыг банк бичил бизнесийн үйл ажиллаганы байгаль орчин, нийтэмд үзүүлж буй нөхөөллийг үнэлэхэд ашиглана)

№	Ангилал	Үнэлгээ	
		Тийм	Шаардлага хангасан эсэх
1	Санал болгож буй бизнес хорилгох үйл ажиллагаанд хамаарч байна уу?		Жижиг зээлийн санхүүжилтэд хамрагдах боломжтүй
2	Санал болгож буй төслийн үйл ажиллагаа дараах антлагалд алинд нь хамаарах вэ?		
2.1	A буюу "Их эрсдэлтэй"	<ul style="list-style-type: none"> • Ой ба мод бэлтгэл • Уул уурхай, кариер • Тамхины үйлдвэрлэл • Цэргийн техник хэрэгслийн үйлдвэрлэл • Кокс, химийн бодис, хуванцар эсвэл эмийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 	Жижиг зээлийн санхүүжилтэд хамрагдах боломжтүй.
2.2	B буюу "Дунд зэрэг нөхөтэй"	<ul style="list-style-type: none"> • Газар тариалан, мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл • Загас агаанур, загасны аж ахуй • Уул уурхайн туслах үйл ажиллагаа • Хүнсний бүтээгдэхүүн эсвэл ундааны үйлдвэрлэл • Цаас эсвэл модны үйлдвэрлэл • Хэвлэх үйлдвэр • Бусад үйлдвэрлэл • Цахилгаан, хий, уур, агааржуулалт, усан хангамж • Барилга • Хөдөлгүүрт тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ • Хоол, ундааны үйлчилгээний үйл ажиллагаа 	<p>Жижиг зээлийн санхүүжилтэд хамрагдах боломжтой.</p> <p>Гэхдээ хяналт тавих шаардлагатай.</p> <p>Бичил бизнес эрхлэгчид Байгаль орчин, нийгэм, эрүүл мэндийн удирдамжийг дагаж мөрдөх шаардлага тавьж, баталгаажуулах шаардлагатай.</p>
2.3	B буюу "Бага ба нөхөтэй"	<ul style="list-style-type: none"> □ Орон сууЧ □ Бөөний & жижигэнэйн худалдаа □ Мэдээлэл, харилцаа холбоо □ Боловсрол, хүний эрүүл мэнд, нийгмийн ажил □ Урлаг, уран сайхан, амралт зуваалга □ Үйлчилгээний бусад үйл ажиллагаа □ Нэхмэл, хувцас, арьсан эдлэлийн үйлдвэрлэл □ Модон эдлэлийн үйлдвэрлэл □ Машин, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, сууринуулалт 	<p>Жижиг зээлийн санхүүжилтэд хамрагдах боломжтой.</p> <p>Гэхдээ хяналт тавих шаардлагатай.</p> <p>Бичил бизнес эрхлэгчид Байгаль орчин, нийгэм, мэндийн удирдамжийг дагаж мөрдөх шаардлагатай.</p>

Хүснэгт 3: Жижиг зээл хүсэгчийн бизнесийн төслийн байгаль орчин, нийгэмд узүүлэх сорөг нөлөөг хязгаарлах, бууруулах шаардлагыг биелүүлэхээ баталгаажуулах маягт (Банк жижиг зээл хүсэгчээр ишлэхийг бөглиүүлээ)

№	Агуулга	Хариулт
1	Төслийн нэр	
2	Төсөлт хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нацжийн нэр	
3	Төсөлт хэрэгжүүлэх байршил	
4	<p>Ямар салбарыг ажиллахаар санал болгох буйгаа</p> <p>Тэмдэглэнэ үү.</p>	<p>А буюу "Их эрсдэлтэй"</p> <ul style="list-style-type: none"> Ой ба мод бэлтгэл Уул Уурхай, карьер Тамхины үйлдвэрлэл Царгийн техник хэрэгслийн үйлдвэрлэл Кокс, химийн бодис, хуванчар эсвэл эмийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл Цаас эсвэл модны үйлдвэрлэл Хэвлэх үйлдвэр Бусад үйлдвэрлэл Цахилгаан, хий, уур, агааржуулалт, усан хангамж Барилга Хөдөлгүүрт тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ Хооп, ундааны үйлчилгээний үйл ажиллагаа
5	<p>Тухайн салбарыг хамаараах байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын тусгай шаардлага, удирдамж (Зөвхөн "Б" антиланд хамаараах үйл ажиллагааны тухайд)</p>	<p>5.1. Та Байгаль орчин, нийгэм, эрүүл мэндийн ерөнхий удирдамжийг дагаж мөрдөхөө баталгаажуулж байна уу?</p> <p>5.2. Та ХНХЯ-аас боловсруулсан Байгаль орчин, нийгэм, эрүүл мэндийн салбарын тусгай шаардлагыг дагаж мөрдөхөө баталгаажуулж байна уу?</p> <p>5.3. Бизнесийн үйл ажиллагаатай холбоотойгоор байгаль орчин, нийгмийн эрсдэлийг бууруулах чиглэлээр таны гүйцэтгэлд хянаант тавих банкны эрхийг та хүлээн зөвшөөрч байна уу?</p> <p>5.4. Жижиг зээлээр санхүүжүүлсэн бизнесийн үйл ажиллагаанаас тань байгаль орчин, нийгэмд томоохон нөлөөлөл үссэн тохиолдолд Банкнаас мэдэгдэх эрхийг та хүлээн зөвшөөрч байна уу?</p>

Хүснэгт 4: Жижиг зээлийн төслийг хэрэгжүүлэх явцад баримтлах байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын өрөнхий удирдамж (Бичил бизнес эрхлэгчид ашиглана)

Нэлөөлөл болон эрсдэл		Анхаарах хүчин зүйлс
Байршил: Хот, суурин газрын байгаль орчныг доройтуулах, хэт бөөгнөрөл, дуу чимээг нэмэгдүүлэх, ялангуяа явган зорчигчдын замын хөдөлгөөнд саад болж хүндрүүлэх, ногон бус болон бусад орчны тохижилт, чиг ширэгт сөргөөр нөлөөлөх, осол гарах буюу эрүүл мэнд, аюулгүй байдлын бусад эрсдэлд хүргэх	(1) Ус ба эрүүл ахуйн үйлчилгээ нь бичил үйлдвэрийг хангахуйц хангалттай байх. (2) Бичил үйлдвэр нь арьс ширийн үйлдвэр, электролизийн аргаар металлаар бүрэх үйл ажиллагаа бүхий эсвэл бохирдуулалт ихтэй бусад бичил үйлдвэртэй ойрхон байрладаггүй байх. (3) Үйлдвэр нь иргэд, хумуусийг нуултан шилжүүлэхийг шаардахгүй байх. (4) Үйлдвэр нь явган хүний зам эсвэл бусад төрлийн замууд эсвэл замын хөдөлгөөний бөглерел, түгжрэл, гацаанд ихээр нөлөөлж, нэмэрлэдэгтгүй байх. (5) Үйлдвэр нь орон байр, хөдөө аж ахуй гэх мэт эмзэг газар ашиглалтаас хол зайдтай байрладаг байх (6) Орон байр эсвэл хөдөө аж ахуйн зориулалтгаар ашиглаждаагүй л бол үйлдвэр нь орон байр, хөдөө аж ахуйн зориулалтгаар ашиглажад тохиромжгүй эсвэл тохиромж муутай газар байх (7) Тухайн газар нь гоо зүйн эсвэл соёлын ач холбогдол багатай эсвэл ногон бус гэж үнэлэгдээгүй байх. (8) Шинэ бичил үйлдвэрийн байршил эсвэл үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөхгүй байгаатай холбоотой асуудлыг орон нутгийн иргэдтэй зөвлөлдөх. (9) Хамгийн үр ашигтай, бодхирдлолтуй эх үүсвэр бүхий эрчим хүчийг ашиглахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	Ажлын талбайг сонгоходо дараах зүйлсийг анхаарна. Үүнд: (1) Ус ба эрүүл ахуйн үйлчилгээ нь бичил үйлдвэрийг хангахуйц хангалттай байх. (2) Бичил үйлдвэр нь арьс ширийн үйлдвэр, электролизийн аргаар металлаар бүрэх үйл ажиллагаа бүхий эсвэл бохирдуулалт ихтэй бусад бичил үйлдвэртэй ойрхон байрладаггүй байх. (3) Үйлдвэр нь иргэд, хумуусийг нуултан шилжүүлэхийг шаардахгүй байх. (4) Үйлдвэр нь явган хүний зам эсвэл бусад төрлийн замууд эсвэл замын хөдөлгөөний бөглерел, түгжрэл, гацаанд ихээр нөлөөлж, нэмэрлэдэгтгүй байх. (5) Үйлдвэр нь орон байр, хөдөө аж ахуй гэх мэт эмзэг газар ашиглалтаас хол зайдтай байрладаг байх (6) Орон байр эсвэл хөдөө аж ахуйн зориулалтгаар ашиглаждаагүй л бол үйлдвэр нь орон байр, хөдөө аж ахуйн зориулалтгаар ашиглажад тохиромжгүй эсвэл тохиромж муутай газар байх (7) Тухайн газар нь гоо зүйн эсвэл соёлын ач холбогдол багатай эсвэл ногон бус гэж үнэлэгдээгүй байх. (8) Шинэ бичил үйлдвэрийн байршил эсвэл үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөхгүй байгаатай холбоотой асуудлыг орон нутгийн иргэдтэй зөвлөлдөх. (9) Хамгийн үр ашигтай, бодхирдлолтуй эх үүсвэр бүхий эрчим хүчийг ашиглахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
Амьдралын орчин, онгон зэрлэг байгаль	(1) Газрын төрх байдлыг аль болох хамгийн бага түвшинд өөрчилж (2) Төслийн бусийн байгалийн суваг шуудууг өөрчлөхгүй хэвээр үлдээх, хөндөхгүй байх (3) Тухайн бусэд ховор эсвэл нэн ховордсон ургамал эсвэл амьтны төрөл зүйл байгаа нь мэдэгдсэн эсвэл байгаа гэж тооцдог бол амьд байгаль, түүний ан амьтдыг сүйтэхгүй байх. (4) Модыг боломжит хамгийн их хэмжээтээр аврахын тулд тохируулга өөрчлөлт хийх (5) Мод тарижаар төлөвлөх	Газрын төрх байдлыг аль болох хамгийн бага түвшинд өөрчилж Төслийн бусийн байгалийн суваг шуудууг өөрчлөхгүй хэвээр үлдээх, хөндөхгүй байх байгаа гэж тооцдог бол амьд байгаль, түүний ан амьтдыг сүйтэхгүй байх. Модыг боломжит хамгийн их хэмжээтээр аврахын тулд тохируулга өөрчлөлт хийх Мод тарижаар төлөвлөх
Байгалийн неөцийн ашиглалт	(1) Боломжит хамгийн бага хэмжээтэй орцуу материал ашиглах (2) Эрчим хүчиний өөр эх үүсвэр ашиглахыг зорих (3) Дахин ашиглах, дахин боловсруулах (4) Гүний усыг хамгаалах	Боломжит хамгийн бага хэмжээтэй орцуу материал ашиглах Эрчим хүчиний өөр эх үүсвэр ашиглахыг зорих Дахин ашиглах, дахин боловсруулах Гүний усыг хамгаалах

<p>Хог удирдлага/асгарч зүйлээс бохирдох</p>	<p>хаягдлын гоожсон</p>	<p>(1) Болзошгүй хог хаягдлыг тодорхойлох (2) Хог хаягдлын хэмжээг боломжит хамгийн бага тувшинд байлагах (3) Өөр зориулалтаар ашиглах (4) Хог хаягдлыг дахин ашиглах төлөвлөгөө бэлтгэх (5) Орчинд зохицтоогоор агуулах, хадгалах, харьцах (6) Үндэсний дурэм журам, Дэлхийн Банкны Орчин, Эрүүл Мэнд, Аюулгүй байдлын шаардлагатай, удирдамжийн дагуу аюулгүй зайнгуулах (7) Ослын үед ямар арга хэмжээ авах тухай төлөвлөгөө боловсруулах (8) Бүх төрлийн хорт угаанд хянналт тавих (9) Боловсруулаагүй, түүхий & бохирдсон усыг ширгэдэгтгүй, ширгэдэг усны суварт эсвэл аливаа усны эх үүсвэр & усан сангийн ойролцоо гадагшлуулахыг хүлээн зөвшөөрөх ёсгүй. (10) Байгууламжийн үйл ажиллагааны хог хаягдлын байгаль, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг боломжит хамгийн бага хэмжээнд байлагах явдлыг хангах. (11) Үйлдвэрлийн бояхир ус, хог хаягдап материалыг хадгалж харьцах байршуулж оноох. (12) Ажлын байрыг цэвэр байлгаж, ажлын байрнаас бүх хотигийг зайлгуулах, хог хаягдлын сав байрлуулах, барилгын хогийг зохих байршилд зайлгуулж хаях. (13) Ашиглалттай орхисон худагт эсвэл ойр орчимд хог хаягдап шидэх, хаях эсвэл булахыг хатуу хориглох, сонгах, (14) Түүхий эд материал, эцсийн бүтээгдэхүүн, бараж хэрэгсэл болон эд зүйлсийг хадгалах тусгай газрыг (15) Орчны шалан дээр ус, тос, шингэн хаягдап астгач үлдэхээс үрдүүлж сэргийж тэвши, хаягт ашиглах.</p> <p>Хөдөлмөрийн байдал, эрүүл ахуй</p> <p>аюулгүй</p>
		<p>(1) Тоос, утас, дуу чимээ, унэр эсвэл бохидуулагч бодисын улмаас ажилчад учирч болох хөдөлмөрийн эрүүл Мэнд, аюулгүй байдлын эрдээлийг үнэлж, тэдгээрийг бууруулах арга хэмжээг эрүүл Мэнд, аюулгүй байдлын үндэсний холбогдох стандарт, Дэлхийн Банкны байгаль, орчин ба нийтийн аюулгүй байдлын ерөнхий шаардлага, удирдамжтай нийцүүлэн санал болгох (2) Ажлын байранд хог хаягдлыг гадагшлуулах ба зайлтулахад зориулагдсан хангаттай байгууламжийг байршуулж, аюултай хортой бодис, аюултай хог хаягдлай хэрхэн харьцах журмыг боловсруулан мөрдөг байх ёстой. (3) Эрсдээлийг бууруулахын тулд ажиллах орон зайг дахин зохион байгуулж, эмх цэгц, цэвэр байдлыг хангах, үр ашигийг нэмэгдүүлэх. (4) Барилга байгууламж доторх үйл ажиллагааг зохиц агааржуулалтаар хангасан байж. (5) Тамхи татах, согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох. (6) Ядарсны улмаас осоп эндэгдэл гаргахгүй тулд буюу хэт их дуу чимээ, машин механизмын чичиргээ доргиноос үүсэх тавгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийг бууруулахын тулд ажиллах хугацааг бууруулах; түр амрах хугацаа гаргах. (7) Зохицтой гэрэлтуулгээр хангах</p>

	<p>(8) Гэмтээх эсвэл хортой бодистой харьцсаны дараа гараа сайтар угаах, хоол идэх, шингэн зүйл уух, тамхи татах эсвэл бие засах газарт орсны дараа гараа сайтар угаах.</p> <p>(9) Бензинийг цвэрлээний зориулалтаар огт ашиглахгүй байх.</p> <p>(10) Ихэнх гэмтэл ажилчдын бие махбодын ялгаатай байдлын улмаас үсдэг. Хумусийн биеийн өндөр, хүч чадал, оюуны стресс даах чадвар зэргийг харгалзах.</p> <p>(11) Хортой бодистой харьцах уед зохих хамгаalaх хэрэгсэл ашиглаж буй эсэхийг жянлан баталгаажуулах.</p> <p>(12) Төхөолилдоор хордсон тохиолдолд аврах бэлтгэлийг хангаж ойрхон цэвэр ус хадгалах, хамтран ажиллагчдаа ямар төрлийн пестицид ашиглаж буй болон шошго тэмдэглэгээ нь хаанаа байгааг хэлэх.</p> <p>(13) Хэрвээ пестицидээр амьстапсан бол, тухайн ажилчныг нэн даруй цэвэр агаарт гаргах.</p> <p>(14) Сав баглаа боодолд сонин болон бусад галд амархан шатах материал ашиглахаас зайлсхийх.</p>
Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	<p>(1) Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлын үндэсний холбогдох стандарт, Дэлхийн Банкны орчин ба нийгмийн аюулгүй байдлын ерөнхий шаардлага, удирдамжтай нийцсэн байх</p>
Ажиллах нөхцөл	<p>(1) Хөдөлмөрийн болон ажиллах нөхцөлтэй холбоотой үндэсний хөдөлмөрийн стандартуудыг дагаж мөрдөх</p> <p>(2) Хөдөлмөр эрхтэлтэй холбоотой үндэсний хөдөлмөрийн стандартуудыг дагаж мөрдөх</p> <p>(3) Орон нутгийн иргэд, олон нийтгэй сайн харилцаа тогтоох</p> <p>(4) Монгол Улсын хуулийн дагуу хөдөлмөр эрхлэх зөвшөөрөгдсөн насааас бага наасны хүүхэд ажиллуулахгүй байх</p> <p>(5) 2008 онд баталсан жагсаалтын дагуу хүүхэд ажиллахыг хориглосон ажил мэргэжилд бага наасны хүүхэд ажилтуулахгүй байх.</p>

Хүснэгт 5: Бичил бизнес эрхлэгчдийн байгаль орчин, нийгэмд узүүлэх нөлөөлөлд хяналт тавих загвар

(Банк бичил бизнес эрхлэгчдийн хийсэн үр дүн, нөлөөллийг бууруулах арга хэмжээг хянах, бүртгэхэд ашиглана)

№	Бичил бизнес эрхлэгчийн нэр	Аймаг/ дүүрэг	Бизнесийн салбар	Байгаль орчин, нийгэмд узүүлж буй серөг нөлөө (Сөрөг нөлөө байгаа бол (✓) тавина уу/					Арга хэмжээ (Сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ абсан бол (✓) тавсна уу)	
				Агаар, хөрс, усны бохирдол	Хог хаядал зайпуулах	ХАБЭА	Ажлын Цаг, Цалингийн доод хэмжээ	Олон нийтэд узүүлэх нөлөө (дүү чимээ, замын түгжрэл гэх мэт)	Албан хөдөлмөр эрхлэлт	
1										
2										
3										
4										
5										
6										
7										
8										
9										
10										
11										
										Нийт

Хүснэгт 6: Жижиг зээлийн санхүүжилтээр хэрэгжиж буй бичил бизнесийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний тайлангийн маягт

(Энэхүү маягтыг банктай байгуулах гэрээнд хавсаргах бөгөөд банк “Б” антилал болуулд зорилж нөлөөтэй ашигландах ашиглана.)

№	Байгаль орчин, нийгэмд дунд зэргийн нөлөө үзүүлэх салбарууд	Үнэлгээ хийгдсэн бичил бизнесийн тоо	Байгаль орчин, нийгэмд сэргэг нөлөө үзүүлж буй бичил бизнесийн тоо						
			Агаар, хөрс, усны бодхицал	Хог хаягдал зайлгуулах	ХАБЭА	Ажлын цаг, цалингийн доод хэмжээ	Олон нийтэд үзүүлэх нөлөө (дүү чимээ, замын түжрэл гэх мэт)	Албан хөдөлмөр эрхпэлт	Хүүхдийн хөдөлмөр
1	Газар тариалан, мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл								
2	Уул уурхайн туслах үйл ажиллагаа								
3	Хүнсний бүтээгдэхүүн эсвэл ундааны үйлдвэрлэл								
4	Цаас эсвэл модны үйлдвэрлэл								
5	Даавуу, нэхмэл эдлэл, хувцас, арьсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл								
6	Бусад үйлдвэрлэл								
7	Хэвлэх үйлдвэр								
8	Цахилгаан хий, уур, агааржуулалт, усан хангамж								
9	Барилга								
10	Хөдөлгүүрт тээврийн хэрэгслийн засвар Үйлчилгээ								
11	Бусад								
	НИЙТ								